

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААН-
БААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ХАМТАРСАН
ТУШААЛ, ЗАХИРАМЖ

1997 оны 01 дугаар
сарын 01 -ны өдөр

Дугаар 1/08 4/6

Улаанбаатар
хот

Нийслэл дэх эрүүл мэндийн бай-
гууллагын бүтэц, зохион байгуу-
лалтыг боловсронгуй болгох за-
риг арга хэмжээний тухай

Удирдлагын мэт данжлагыг цөөлөх, ажил үйлчилгээний давхардлыг
арилгах, барилга байгууламжийн амигдалтыг сайжруулах замаар нийс-
лэл дэх эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг бо-
ловсронгуй болгох зорилгоор Засгийн газрын 1996 оны 11 дүгээр сарын
28-ны өдрийн хуралдааны 50 дугаар тэмдэглэл 1997 оны 07 дугаар тог-
тоолыг үндэслэн ТУШААХ НЬ:

НЭГ. Дор дурдсан зохион байгуулалтын арга хэмжээг энэ оны 1
дүгээр улиралд багтаан авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэнд, нийгмийн
хамгааллын яамны Анагаах ухааны эмнэлгийн хөгжлийн газар (Л.Жан-
балжав), Нийгмийн эрүүл мэндийн газар (Х.Энхжаргал), Нийслэлийн
Засаг даргын Эрүүл мэндийн газар (Г.Буян-Өлзий), дүүргийн Засаг
дарга нарт даалгасугай:

1/ Нэгдсэн 1, 2, 3, 4 дүгээр эмнэлэг, Хүүхдийн нэгдсэн 1, 2
дугаар эмнэлэг, дүүргүүдийн эрүүл мэндийн зөвлөх төвүүдийг тус тус
татан буулгаж, хүүхэд, насанд хэрэгчдэд үйлчлэх "Эрүүл мэндийн
нэгдэл" болгон хэвсрэлтанд заасны дагуу мивээр зохион байгуулах;

2/ "Баянгол" дүүргийн Ү Ү1 хорооны хөдөлмөрчдийг Анагаах
ухааны үндэсний хүрээлэнгийн поликлинижээр үйлчлүүлж Баянгол
дүүргийн эрүүл мэндийн зөвлөх төвийг "Эрүүл мэндийн нэгдэл"-ийн
статустай ажиллуулах.

3/ Нийслэлийн эрүүл ахуй халдвар судлалын төвийг татан
буулгаж, Нийслэлийн эрүүл ахуй халдвар судлалын хяналтын алба
байгуулсугай.

4/ Эрүүл ахуй халдвар нэн судлалын үндэсний төвийг татан
буулгаж, тус төвийн халдварт өвчнийг хянах алба, нэн судлалын
төв лаборатори, бруцелёзын алба, ДОХ бэлгийн замын халдварын
давлагаа төв, Нийслэлийн эрүүл ахуй халдвар судлалын төвийн
бүтэцэд ажиллаж байсан халдвар судлалын үйлчилгээний хэсгүүдийг
нэгтгэн, халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх чиг үүрэг бүхий
улс нийслэлийн үйлчилгээтэй Халдварт өвчин судлалын төвийг
Халдвартын клиникийн эмнэлэгтэйгээр 1997 оны 1 дүгээр сарын
16-ны өдрөөс эхлэн байгуулж, Халдвартын клиникийн эмнэлгийн
цогцолборын 1а дугаар байранд байрлуулсугай.

5/ Эрүүл ахуй, халдвар, нян судлалын үндэсний төвийн бүтцэд ажиллаж байсан эрдэм минжилгээний салбарыг Нийгмийн эрүүл мэндийн институт болгон өөрчлөн зохион байгуулсугай.

6/ Ахуйн мавьж мэрэгчтэй тэмцэх төвийг Халдварт өвчин судлалын төвийн харьяанд аж ахуйн тооцоон дээр, Биобэлдмэлийн үйлдвэрийг Нийгмийн эрүүл мэндийн институтын харьяанд тус тус бие даалган ажиллуулсугай.

7/ С.Цоодолыг Эрүүл ахуй халдвар нян судлалын үндэсний төвийн захирлын үүрэгт ажлаас 1997 оны 1 дүгээр сарын 15-наар тасалбар болгон чөлөөлсүгэй.

8/ Халдварт өвчин судлалын төвийн захирлаар Л.Тогоочийг, Нийгмийн эрүүл мэндийн институтын захирлаар Л.Нарантуяаг 1997 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс тус тус томилж, Тогоочийн цалинг ТУ-11 зэрэглэлээр 32300 төгрөгөөр Нарантуяагийн цалинг ТУ-11 зэрэглэлээр 32300 төгрөгөөр тус тус тогтоосугай.

9/ Эрүүл ахуй халдвар нян судлалын үндэсний төв дэх Улсын халдвартын фондыг Халдварт өвчин судлалын төвд шилжүүлсүгэй.

10/ Шинээр зохион байгуулагдаж байгаа Халдварт өвчин судлалын төв, Нийгмийн эрүүл мэндийн институтын дүрмийг боловсруулж батлуулах, комисс томилон эдгээр байгууллагуудын холбогдох орон тоо, төсвө, хөрөнгийг бүртгэлийн дагуу шилжүүлэн ажил хүлээлцүүлж, дунг сайдны зөвлөлийн хуралд танилцуулахыг үүрэг болгосугай.

ХОЕР. Нийслэлийн Засаг даргын Эрүүл мэндийн газар
/Г.Буян-Өлзий/-т даалгах нь:

1. Бүтэц зохион байгуулалтын энэ арга хэмжээтэй холбогдуулан нийслэлийн эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын алба, эрүүл мэндийн нэгдлүүдийн дүрмийг шинэчлэн баталж, халдварт өвчин судлалын төвийн орлогч захирал болон нийслэлийн ерөнхий халдвар судлагч нарыг томилон Эрүүл мэндийн нэгдлийн дарга, ерөнхий эмч нартай хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллуулсугай.

2. Нийслэл дэх эрүүл мэндийн нийт байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, хяналт тавих, санхүүгийн тайлан тэнцэл, статистикийн тайлан мэдээг зохиж журмын дагуу гаргуулан нэгтгэж, судалгаа дүгнэлт хийж, ЭМНХЯ, Засгийн газрын агентлагууд, нийслэлийн төрийн захиргааны холбогдох байгууллагыг шаардагдах мэдээ мэдээллээр хангаж ажилласугай;

3. Нийслэл дэх эмнэлгүүдийн барилгын хүчин чадал, нэг өвчтөнд ногдох талбайн норматив зэргийг үндэслэн орны тоог шинэчлэн тогтоож мөрдүүлэх арга хэмжээ авсугай.

ГУРАВ. Шинээр байгуулагдаж байгаа Эрүүл мэндийн нэгдлийн дарга нарыг Нийслэлийн Засаг даргын Эрүүл мэндийн газрын даргатай зөвшилцсөний үндсэн дээр томилон ажилдуулахыг дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ДӨРӨВ. Нийслэл дэх эрүүл мэндийн зарим байгууллагуудын бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орж байгаатай холбогдуулан тэдгээрийн 1997 оны төсөв, төлөвлөгөөг дахин хянаж, зохицуулалт хийхийг Эдийн засаг, зохицуулалтын газар (Д.Баярсайхан), Эдийн засаг, нийгмийн бодлогын хэлтэс (Ч.Бат), Санхүүгийн хэлтэс (С.Гомгор), Эрүүл мэндийн газар (Г.Бужин-Өлзий), дүүргүүдийн засаг дарга нарт даалгасугай.

ТАВ. Энэ тухаал, захирамж гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн хэм, Улаанбаатар хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны А/39, 83 тоот тухаал, тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар заалт, 3 дугаар хавсралтын 18, 41, 42, 43, 44, 46, 48, дугаар заалтууд, Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 1994 оны А/110, А/183 тоот тухаал, захирамжийг тус тус хучиггүй болсонд тооцсугай.





НИЙСЛЭЛ ДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРИМ
БАЙГУУЛЛАГУУДЫН ШИНЭЧЛЭН ТОГТООСОН НЭРШИЛ

No :	Эмнэлэг, төвүүдийн хуучин нэршил	Шинэ нэршил
1.	Хүүхдийн нэгдсэн 1-р эмнэлэг Нэгдсэн 1-р эмнэлэг "Найрамдал" эрүүл мэндийн зөвлөх төв	"Баянзүрх" Эрүүл мэндийн нэгдэл
2.	"Сүхбаатар" Эрүүл мэндийн зөвлөх төв Хүүхдийн 2-р нэгдсэн эмнэлэг	"Сүхбаатар" Эрүүл мэндийн нэгдэл
3.	"Октябрь" эрүүл мэндийн зөвлөх төв Нэгдсэн 3-р эмнэлэг	"Сонгино хайрхан" Эрүүл мэндийн нэгдэл
4.	"Чингэлтэй" эрүүл мэндийн зөвлөх төв Нэгдсэн 4-р эмнэлэг	"Чингэлтэй" Эрүүл мэндийн нэгдэл
5.	Нэгдсэн 2-р эмнэлэг "Ажилчин" эрүүл мэндийн зөвлөх төв	"Хан-Уул" Эрүүл мэндийн нэгдэл